



**YAG**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН  
2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл  
дараах хаягаар харилцана уу:**

ТАГ-ын дарга, Тэргүүлэх аудитор :

Ч. Эрдэнэбаатар

Утас: 70562112 70562147

Аудитын менежер :

Д.Оюунтуяа

Утас: 70562147

Хаяг:

Хэнтий аймгийн Аудитын Газар

Хэнтий аймаг

Хэрлэн сум

Сариг баг

Монгол улс

Цахим хуудас:

[www.khentii@audit.gov.mn](http://www.khentii@audit.gov.mn)

**АУДИТЫН ТАЙЛАН**

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитын гэрчилгээ

Хавсралт 3: Менежментийн захидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн тайлан

“Ай Жэй Эй Эйч Аудит” ХХК

Захирал: Г.Энхмаа

Утас: 99040059 450279

Цахим хаяг:

[ljah\\_audit\\_2008@yahoo.com](mailto:ljah_audit_2008@yahoo.com)

## АГУУЛГА

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго, үйлажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Дотоод хяналт
6. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
7. Шилэн дансны мэдээлэл
8. Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар
9. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар
10. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар
11. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар
12. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
13. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
14. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл
15. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
16. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

## 1.Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Төсвийн тухай хуулийн 8.9.8, Төрийн аудитын тухай хуулийн 15.1-д заасныг үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 18.2 дугаар зүйлд заасан бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд ХЭА-/2018 /21/СТА-ХАК-ТӨҮГ аудит хийлээ.

Аудитыг Төсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Санхүүгийн тайлагналын Олон улсын стандарт /СТОУС/, түүнд нийцүүлэн гаргасан нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Байгууллагын удирдлага санхүүгийн тайлангаа СТОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, програм хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, СТОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны санхүүгийн тайланд санхүүгийн тайлангийн аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 03-аас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд хийхээр төлөвлөн Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-ний аудитор хэрэгжүүлэв. /ТАБ-СТА-А-9/

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны санхүүгийн тайланг 2018 оны 02 дугаар сарын 06 -нд Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д ирүүлсэн байна.

Ай Жэй Эй Эйч Аудит ХХК нь аудитыг 2018 оны 01 дүгээр сарын 03-аас 2018 оны 02 дугаар сарын 25-ны хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25-нд Хэнтий аймаг дахь Нисэх буудлын удирдлагад гардуулна.

## 2.Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

Хэнтий аймгаг дахь Нисэх буудлын удирдлага нь Монгол улсын “Төсвийн тухай”, “Иргэний нисэхийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай”, “Нийгмийн даатгалын тухай”, “ХХОАТ-ын тухай”, “Төрийн албаны тухай”, “Нягтлан бодох бүртгэлийн тухай”, “Хөдөлмөрийн тухай” хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомж түүнд нийцүүлэн гарсан журам, зааварт өөрчлөлт ороогүй байна.

## 3.Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

Иргэний нисэхийн тухай хуулийн 1 дүгээр зүйлд “ Монгол улсын агаарын зайд иргэний агаарын хөлгөөр нислэг үйлдэх, нисэхийн аюулгүй ажиллагаа болон аюулгүй байдлыг хангахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино”гэсний дагуу орон нутгийн нисэх буудал “Иргэний нисэхийн салбарт аюулгүй, үр ашигтай, тогтвортой үйлчилгээ үзүүлэх “ зорилгыг хангах үйл ажиллагааны зорилтууд дэвшүүлж, чиг үүргээ хэрэгжүүлж ирсэн байна.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай” хуулийн 18 дугаар зүйлийн 18.1-д “Аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын өдөр тутмын үйл ажиллагааг үйлдвэрийн газрын захирал удирдана” гэж заасны дагуу Хэнтий аймаг дахь Нисэх буудлын дарга нь удирдаж эд хөрөнгийг захиран зарцуулж байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна гэж заасны дагуу Хэнтий аймаг дахь Нисэх буудлын захирал Төсвийн захирагчийн үүргийг гүйцэтгэж байна.

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны жилийн төсвийг Иргэний Нисэхийн Ерөнхий газраас баталж санхүүжилтийг Төрийн банкны харилцах дансаар дамжуулан зарцуулж байна.

Төсвийн шууд захирагчтай холбоотой хууль эрх зүйн баримт бичгийг судалсан бөгөөд байгууллагатай холбоотой Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулиудыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

**4.Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын арга зүй, хэрэгжүүлсэн горим,  
Хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:**

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,СТОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Хэнтий аймгийн Нисэх буудлын 2017 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар 7 дансанд 12 аудитын нарийвчилсан горим, сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Тухайн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Хэнтий аймаг дахь Нисэх буудлын санхүүгийн үйл ажиллагаанд хэрэглэгдэх нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг ИНЕГ –аас боловсруулан мөрдөж ажилласан байна. Тайлант жилд санхүүгийн програм өөрчлөгдөж Интерактив ХХК -н “Veritech ERP” програмаар 2017 оны 1 дүгээр сараас нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлангаа бэлтгэсэн байна. Програм нь СТОУС- тай нийцсэн байна.

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын санхүүгийн үйл ажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах үйл ажиллагааг санхүүгийн програмаар боловсруулан санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу бэлтгэсэн байна.

**5.Дотоод хяналт:**

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм. Хэнтий аймаг дахь Нисэх

буудлын дотоод хяналт эрсдлийг төлөвлөлтийн үед бага гэж тооцсон ба дахин хянахад дотоод хяналт хангалттай байна.

#### **6.Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:**

2017 оны батлагдсан төсвийг сар, улирлын хуваарийн дагуу ИНЕГ аас хуваарилан Төрийн банкны харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн санхүүжилтийн гүйцэтгэлийг хангах, төсвийг зардлын төрөл зүйлээр хуваарилан гүйцэтгэлд хяналт тавин ажилласан байна.

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын удирдлага нь 2017 онд улсын төсвөөс урсгал зардалд 400,621.1 мянган төгрөгийн санхүүжилт авч, үндсэн үйл ажиллагаанаас 2,169.0 мянган төгрөг, систем хоорондын болон бусад орлогоор 36,890.9 мянган төгрөг нийт 439,681.0 мянган төгрөг олж, борлуулсан бүтээгдэхүүний өртөг зардалд 467,230.5 мянган төгрөг, удирдлагын зардалд 39,823.6 мянган төгрөгийг зарцуулж (67,373.1) мянган төгрөгийн алдагдалтай ажилласан байна.

#### **7.Шилэн дансны мэдээлэл**

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын вэб сайтад шилэн дансны талаар [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) сайтад 2017 онд батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэл, хөрөнгө оруулалт, бусад зардлыг 12 сарын байдлаар оруулсан байна.

Шилэн дансны хуулийн хэрэгжилт хангалттай байна.

#### **8.Олж тогтоосон гол эрсдлүүд, түүний үр дагавар:**

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд данс бүрээр нийт 12 нарийвчилсан горим, сорил гүйцэтгэв.

Үр дагаврыг тодорхойлж чадвал: Тайлант жилд өөрийн үйл ажиллагааны орлогын төлөвлөгөөг тасалсан. Үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны гүйцэтгэлүүдийг тусгаагүй байна. Бидний түүврээр тус байгууллагын нягтлан бодох бүртгэлийн үндсэн хөрөнгийн дэлгэрэнгүй бүртгэл, болон тооллогоор элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгө их хэмжээтэй байна. /түүврийг хавсаргав/. Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо Засгийн газрын 233-р тогтоолоор баталсан журамд заасан хугацааг баримталсан зэрэг зөрчлүүд нь санхүүгийн

тайлангийн иж бүрэн байх, үнэн зөв байдал, хэмжилт, тодруулга ба толилуулга, эрх ба үүрэг эдгээр батламж мэдэгдлүүдийн шаардлагыг хангахгүй байна.

### **9.Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:**

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, цалин нийгмийн даатгалын шимтгэл, авлага, өглөг, томилолт, шуудан холбоо, нэг удаагийн тэтгэмж, зэрэг дансанд ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан горим, сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

Эдгээр шалгасан горим, нарийвчилсан сорил нь тус байгууллагын нийт орлогын 90%, мөнгөн хөрөнгийн 90%, нийт зардлын 80% -ийг тус тус эзэлж байна.

Аудитаар ҮАГ-аас нэгдсэн журмаар авч байгаа 12 судалгааг гаргаж ирүүлсэн байна.

### **10.Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:**

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.Төлөвлөлтийн үед материаллаг байдлыг 2016 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 1% буюу 5,662.6 мянган төгрөгөөр тооцов./ТАБ-СТА-А-4/ Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг дахин тооцож 2017 оны 4-р улирлын орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1% буюу 5,070.5 мянган төгрөгөөр тогтоов. Аудитын явцад материаллаг хэмжээний зөрчил илрээгүй.

Аудитын явцад материаллаг хэмжээний алдаа илрээгүй байна.

### **Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна Үүнд:**

1. Тайлант жилд үндсэн үйл ажиллагаанаас 3,409.1 мянган төгрөг олох төлөвлөгөөтэй байснаас 2,169.0 мянган төгрөг төвлөрүүлж орлогын төлөвлөгөөг 1,240.1 мянган төгрөгөөр тасалсан нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн

төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Орлогыг бүрэн төвлөрүүлж, төлөвлөгөөг биелүүлж ажиллах зөвлөмж өгөх.

2. Үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны гүйцэтгэлүүдийг тусгаагүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүргийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: СТОУС болон санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг хангаж ажиллах зөвлөмж өгөх

3. Бидний түүврээр тус байгууллагын нягтлан бодох бүртгэл болон үндсэн хөрөнгийн бүртгэл тооллогоос ажиглахад элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгө их хэмжээтэй байгаа нь НББОУСтандартын 16.67-д "ирээдүйн эдийн засгийн үр өгөөжгүй болсон хөрөнгийг данснаас хасна", Мөн ТБОНӨТХуулийн 31 дүгээр зүйлийн 3.2-т "илүүдэл эд хөрөнгө болон элэгдэл хорогдлын шимтгэлээр анхны үнийг нь нөхсөн, түүнчлэн нөхөөгүй боловч гэмтэж, засаж сэлбээд өөр зориулалтаар ашиглаж болох эд хөрөнгийн үнийг Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагатай зөвшилцөн тогтоож ашиглана" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна. /түүврийг хавсралтаар гаргав/

Шийдвэрлэсэн нь: Үндсэн хөрөнгийн бүртгэлийн талаарх СТОУС болон санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийг хангаж ажиллах зөвлөмж өгөх.

### **11.Залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:**

Аудитын явцад үндсэн хөрөнгөтэй холбоотой 1 зөрчлийг залруулаагүй болно.



### **12.Анхаарал татахуйц бусад чухал асуудал:**

Анхаарал татахуйц чухал асуудал үгүй байна.

### **13.Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:**

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын үндсэн хөрөнгийн элэгдлийн зардлыг цаг хугацаанаас хамаарч гүйцээж мөшгин шалгах боломжгүй байлаа.

### **14.Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:**

Хэнтий аймгийн орон нутгийн нисэх буудлын 2017 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар мөнгөн дүнгээр илэрхийлэгдэх 1240,1 мянган төгрөгийн, бусад 2 алдаа, зөрчил илэрсэнд зөвлөмж өгөв.

### **15.Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:**

Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-ны аудитор аудит хийж зөрчилгүй санал дүгнэлт өгсөн байна. Хоёр зөвлөмж өгснийг хэрэгжүүлж ажилласан байна.

### **16.Зөрчилгүй санал дүгнэлт**

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, цэвэр хөрөнгө/ өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэл болон илчлэл тодруулгад тайлагнасан үлдэгдэл, ажил гүйлгээнүүд холбогдох хууль, СТОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.


Аудитлагдсан санхүүгийн тайлан 10 хуудас, хавсралтууд 18 хуудас, байгууллагын санал 2 хуудсыг тус тус хавсаргав.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:  
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

АУДИТЫН МЕНЕЖЕР

БЭЛТГЭСЭН:  
АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР ОГНОО:

Д.ОЮУНТУЯА ОГНОО:

Н.УРАНЧИМЭГ ОГНОО: 2018.02.25



**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ  
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

23119 Хэнтий аймаг, Хэрлэн сум, Сариг баг  
Утас: 70-56-21-47, Факс: 70-56-21-12  
E-mail: [khentii@audit.gov.mn](mailto:khentii@audit.gov.mn)

2018.2.28 № 06/34  
танай \_\_\_\_\_ -ны № \_\_\_\_\_ -т

**ХЭНТИЙ АЙМГИЙН ОРОН  
НУТГИЙН НИСЭХ БУУДЛЫН  
ДАРГА Д.ЦЭРЭНДОНДОВ  
ТАНАА**

**Аудитын гэрчилгээ**

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, тодруулгад санхүүгийн тайлангийн аудит хийв.

**Зөрчилгүй санал дүгнэлт**

Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт болон мөнгөн гүйлгээний тайланг материаллаг зүйлсийн хувьд Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон хобогдох стандартад нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

**Санал дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Хэнтий аймаг дахь Нисэх буудлын 2017 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, тодруулга дах үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

**Үүрэг, хариуцлага**

Хэнтий аймаг дахь Нисэх буудал нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт болон холбогдох, бусад стандарттай нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

0500469

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР



**УАГ**  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

## ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ НИСЭХ БУУДЛЫН 2017 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

### МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

#### Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1	
Орлогын талаар.....	3
Асуудал 2	
Санхүүгийн тайлангийн талаар.....	4
Асуудал 3	
Үндсэн хөрөнгийн талаар .....	5

2018 оны 2 дугаар сар

## **Менежментийн захидал**

Хэнтий аймгийн Төрийн Аудитын газар аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Хэнтий аймаг дахь Нисэх буудлын удирдлагад зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын сул тал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан Хэнтий аймаг дахь Нисэх буудлын санхүүгийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Зөвлөмжийн хэрэгжилтийн тайлан, албан тоотыг 2018 оны 9 дүгээр сарын 30-ны дотор Хэнтий аймгийн Аудитын Газар болон Ай Жэй Эй Эйч Аудит ХХК-д хүргүүлнэ үү.

### АГ-ын ажиглалт

Тайлант жилд үйл ажиллагааны орлогыг 1,240.1 мянган төгрөгөөр тасалсан байгаа нь Төсвийн тухай хуулийн 41.2.1-д "Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх" гэж заасныг мөрдөж ажиллаагүй байна.

### АГ-ын зөвлөмж

Цаашид холбогдох хуулийг хэрэгжүүлж орлогын төлөвлөгөөг биелүүлж ажиллах.

### Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, хэмжилт, толилуулга ба тодруулга, иж бүрэн байдал гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.

### Төсвийн захирагчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, албан тоотоор баталгаажуулсан болно.

### АГ-ын ажиглалт

Үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлтийн тайланд өмнөх оны гүйцэтгэлүүдийг тусгаагүй байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Ерөнхий нягтлан бодогчийн эрх үүргийн 20.2.9-д "аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага болон санхүүгийн тайлан хэрэглэгчдийг цаг хугацаанд нь үнэн, зөв мэдээллээр хангах ажлыг зохион байгуулна" гэж заасныг мөрдөж ажиллах.

### АГ-ын зөвлөмж

Санхүүгийн тайлангийн батламж мэдэгдлүүдийн хүрээнд санхүүгийн тайланг бэлтгэхийг зөвлөж байна.

### Эрсдлүүд

Санхүүгийн тайлангийн оршин байх, иж бүрэн байх, толилуулга ба тодруулга, эрх ба үүрэг, үнэн зөв байдал эдгээр батламж мэдэгдлүүдийг зөрчих эрсдэлтэй.

### Төсвийн захирагчийн хариу

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.



**АГ-ын ажиглалт**

Бидний түүврээр тус байгууллагын үндсэн хөрөнгийн бүртгэл тооллогоор элэгдлээрээ өртгөө нөхсөн хөрөнгө их хэмжээтэй байгаа нь НББОУССтандартын 16.67-д "ирээдүйн эдийн засгийн үр өгөөжгүй болсон хөрөнгийг данснаас хасна", Тайлант хугацаанд үндсэн хөрөнгөнд элэгдэл тооцохдоо Засгийн газрын 233-р тогтоолоор баталсан журамд заасан хугацааг баримталсан нь уг тогтоол хүчингүй болсон байна.

**АГ-ын зөвлөмж**

НББОУС-н 16-д заасан үндсэн хөрөнгийн бүртгэлийн стандартыг мөрдөх, Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт элэгдэл тооцох арга, ашиглах хугацааг тодорхой заахыг зөвлөж байна.

**Эрсдлүүд**

Санхүүгийн тайлангийн үнэн зөв байдал, оршин байх, хэмжилт, эрх ба үүрэг гэсэн батламж мэдэгдлүүдийг хангахгүй байх эрсдэлтэй.


**Төсвийн захирагчийн хариу**

Аудитын асуудлын бүртгэлийг үйлчлүүлэгчийн удирдлага, санхүүгийн ажилтнуудад танилцуулж, баталгаажуулсан болно.

МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДЛЫГ


ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.ЭРДЭНЭБААТАР Огноо:


АУДИТЫН МЕНЕЖЕР




Д.ОЮУНТУЯА Огноо:

БЭЛТГЭСЭН:

АУДИТОР



2317144297  
СХАА0046 0074002



Н.УРАНЧИМЭГ Огноо: